

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОХ ГЭРЭЭ

2023 оны 01 сарын 16 өдөр

№ 19

Хархираа

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу
нэг талаас

Увс аймаг Тариалан сум Засаг Дарга З. Тэгнжаргал, нөгөө талаас “Галдан бошигт”
нөхөрлөл, (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч
(албан тушаал) С.Сайнжаргал, гуравдагч талаас увс аймгийн бичил уурхайчдын “Эвийн
хүч Эвсэг холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны захирал Д.Чойжилсүрэн нар (цаашид хамтад
нь “Галууд” гэх) дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 01 дугаар сарын 16-
ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) Тариалан суманд байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Тариалан сумын Бор хавцал нэртэй газарт орших
Х:54 82830.1206 У:404020.7834 координат талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 3 сарын
хугацаагаар алт (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сумын Засаг дарга, бичил уурхай
эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр.Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2.1.Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-
ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.бичил уурхай эрхлэгч этгээдэд цогдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг
гэрээнд хавсаргах;

2.1.2.хөг хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

2.1.3. Бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах,
баяжуулах талбайг 10.0м2 (арван метр квадрат)-аас илүүгүй байна.

2.1.4. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг
тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр 350.000 төгрөгийг
Ув.Тариалан ЗДТГ-ын 100151355001 тоот дансанд төвлөрүүлэх.

2.1.5. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж сертификат авсан
нөхөрлөлийн гишүүн бүрт үнэмлэх олгоно.

2.1.6. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс
шаардах.

2.1.7. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт
тавих.

2.1.8. Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

2.1.9. Бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт
хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох.

2.1.10. Бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж, сумын Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах.

3.1.2. Ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах.

3.1.3. Суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаяг длын цэгийг байгуулах.

3.1.4. Гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо бус этгээдийг ажиллуулахгүй байх.

3.1.5. Байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3.1.7. Хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах.

3.1.8. Ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх.

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах.

3.1.11. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах 350,000 /гурван зуун гавин мянган / төгрөгийг Ув.Тариалан ЗДТГ-ын нөхөн сэргээлтийн дундын сангийн 100151355001 тоот дансанд төвлөрүүлэх.

3.1.12. Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах.

3.1.13. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сумын Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх, актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

3.1.14. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулууг худалдах.

3.1.15. Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татварыг бүртгэгдсэн нөхөрлөлийг татварын дэд албыг Тариалан суманд бүртгэлжүүлж Орлогыг тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээний орлогод нөхөрлөлийн гишүүн бүрээр тооцож 30,000 (гучин мянган) төгрөгийг тус сумын Орон нутгийн ерөнхий орлогын 100151300911 тоот дансанд төлөх.

3.1.16. Өөрсдийн хариуцсан нүх шруфыг ээлж солих явцад эзэнжүүлэх тухайн нүхэнд унах, эрсдэл үүсэх аюулыг арилгах, аюулгүй байдлыг хангах, үүсэх эрсдэлийг тухайн нөхөрлөл хариуцна.

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв. Мэргэжлийн холбооны үүрэг

4.1. Төрийн захиргааны байгууллага, сумтай хамтран баталсан хөтөлбөрийн дагуу Бичил уурхайн үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ашигт малтмалын гарал үүсэл, магадлан шинжилгээ, нөхөн сэргээлтийн сургалтыг нөхөрлөлийн гишүүдэд зохих журмын дагуу зохион байгуулах, гэрчилгээ олгох.

4.2. Бичил уурхайчдад гэрчилгээ олгох.

4.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж гэрээний хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийх, хэрэгжилтийн үнэлгээний мэдээллийг Ашигт малтмал газрын госны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх.

4.4. Хууль бусаар бичил уурхай эрхэлсэн болон бусад гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг сумын байгаль орчны тасаг, цагдаагийн хэсэгт мэдээллэх.

4.5. Монгол улсын архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийг удаа дараа зөрчсөн нөхөрлөлийн гурвалсан гэрээг цуцлах үндэслэл болно.

4.6. Шруф хоорондын маргааныг мэргэжлийн холбоо шийдвэрлэнэ.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 01 сарын 16 өдрөөс 2023 оны 04 сарын 16 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ байгуулсан талбайд 3 сарын хугацаанд ажиллаагүй, гэрээ дүгнүүлээгүй бол гэрээг дуусгавар болсонд тооцож, барьцаа хөрөнгөөр нөхөн сэргээлт хийнэ.

6.4. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

7.3. Нөхөрлөлийн гишүүд гэрээний хугацаанд 50.000 төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд Ув. Тариалан ОНХСангийн 100151352400 тоот дансанд байршуулах.

7.4. Гэрээний 3.1.15-д зааснаар төвлөрүүлсэн орлогыг энэхүү гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гарсан зардлыг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээр төлөвлөж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж зарцуулна.

7.5. Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын хэлтэсээс гаргасан дүгнэлттэй талбайн гадна зөвшөөрөлгүй шруф малтсан тохиолдолд зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ авах.

7.6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлуулж энэхүү гэрээнд хавсаргасан байна.

7.7. Монгол улсын архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг удаа дараа зөрчсөн нөхөрлөлийн гурвалсан гэрээг цуцлах үндэслэл болно.

Гэрээ байгуулсан:

Увс аймаг (хот)-ийн Тариалан сум (дүүрэг)-ийн Засаг дарга

/З. Тэгшжаргал/
/эцэг/эх/-ийн нэр



“Галдан бошигт” (нөхөрлөл, хоршоо) төлөөлж

/С.Сайнжаргал/
/эцэг/эх/-ийн нэр

/С.Сайнжаргал/
гарын үсэг

/тамга, тэмдэг/

Увс аймгийн бичил уурхайчдын Эвийн хүч Эвсэг холбоо /ГҮТББ/ төлөөлж

/Д.Чойжилсүрэн/
/эцэг/эх/-ийн нэр

